

**ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ  
ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН “ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН  
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн хүрээнд байгуулагдах Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төв болон Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд баригдаж байгаа Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн чиг үүргийн ялгааны талаар асуулт асууж, хариулт авлаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Хууль баталсантай холбогдуулан авах  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийг баталсантай холбогдуулан Зөрчлийн тухай хууль болон холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийг баталсантай холбогдуулан эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага болон холбогдох бусад байгууллагын албан хаагч, ажилтан, иргэн, хуулийн этгээдэд хуулийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах арга хэмжээг 2026 онд багтаан зохион байгуулах;

3/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагыг байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

4/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагыг байгуулах хүртэл хугацаанд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанд хариуцуулах;

5/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуульд нийцүүлэн Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 11 дүгээр тогтоолыг шинэчлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо /П.Ганзориг/-нд даалгасугай.

Гарын үсэг